

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨ

ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД
Бэлчээрийн менежментийг сайжруулан ажиллана.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хүрсэн түвшин	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1.Хүнс хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хүрээнд							
Газар тариалангийн чиглэлээр							
4.1.1	АЗДҮАХ 4.1.16 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.20	Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор ханган ажиллах	Хүлэмжийн тариалсан талбайг м2-аар нэмэгдүүлсэн байх	300 ^{м2}	УТ-28,8 Хувийн хэвшил-26,4	2020 онд 1540м2 талбай бүхий өвлийн хүлэмж, 10046 м2 талбай бүхий 76 ш зуны хүлэмжид тариалалт хийснээр хүлэмжийн тариалалт өмнөх оноос 1084 м2 талбайгаар нэмэгдсэн байна.	100
			Хураан авах ургацын хэмжээг урьд оноос нэмэгдүүлэх хэмжээ /тн/	5			
			Хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах /өмнөх оноос нэмэгдүүлсэн хувиар/	1,2			
4.1.2	Засгийн газрын 2017-2020 оны үйл	Тариалан эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамруулан хөнгөлөлттэй нөхцлөөр хүлэмж, үр бордоогоор хангаж, тариалалтын	Төсөл хөтөлбөрт хамрагдах тариалан эрхлэгчийн тоог нэмэгдүүлэх	5	УТ-5,1 Төсөл хөтөлбөр-19,0	ХХААХҮЯамнаас “Хүнсний ногоо” хөтөлбөрийн хүрээнд 15 сумын 120 тариаланчид 5.1 сая төгрөгийн үнэ бүхий 146,2 кг хүнсний ногооны үр, Хөдөлмөр Халамж үйлчилгээний газраас хүнсний ногоо тариалах, ажилгүй иргэдийг ажлын байраар	100
			Төмс, хүнсний ногоог тариалах хэмжээ /га/	38			

	ажиллага аны хөтөлбөр	талбайг нэмэгдүүлэх	Төмс, хүнсний ногоо хураан авах ургацын хэмжээ / тн/	228		хангах хөтөлбөрийн хүрээнд Сайнцагаан, Эрдэнэдалай, Сайхан-овоо, Дэлгэрцогт, Өндөршил сумдын 7 бүлгийн 35 иргэнд 19.0 сая төгрөгийн үнэ бүхий төмс, хүнсний ногооны үр 4,6 тн, өргөст хэмх лоолийн 300 ш үрсэлгээ тус тус нийлүүлж дэмжлэг үзүүлээ. Үүний үр дүнд нийт 53,6 га талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалж өмнөх оноос талбайн хэмжээ 18,9 га-гаар нэмэгдсэн байна.	
4.2 Мал аж ахуйн салбарын чиглэлээр							
4.2.1	АЗДҮАХ 4.1.4.	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах	Авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувиар	80	Улсын төсөв 412.0	2020 онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажлын хүрээнд улсын төсвийн 300,0 сая төгрөгний хөрөнгөөр 60 тн бактержуулсан будааг 9 сумын 30,0 мян/га бэлчээрийн талбайд микробиологи, 10 сумын 70,0 га талбайд 112,0 сая төгрөгөөр энгийн механик аргаар тэмцэх ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэлийн үр дүн: Энгийн механик 84.6, микробиологи 84 хувь.	100
			Хамруулах талбайн хэмжээ / мян/га/	50			
4.2.2	АЗДҮАХ 4.1.7.	Хулд сумын тэмээний судалгаа шинжилгээний ажлыг үргэлжлүүлэн хийж омгоор батлуулах	Орон нутагт ХХААХҮЯамны сайдын тушаалаар батлагдсан хянан магадлагаа хийх ажлын хэсгийг ажиллуулах тоо	2	Улсын төсөв 8.7 сая	Хулд сумын “Олдохын хүрэн бор” тэмээг омог болгох ажлын хүрээнд 2020 онд 5000 тэмээнд үзлэг ангилалтын ажил хийсэн. Олдохын хүрэн бор тэмээний омгийн тодорхойлолтыг хүргүүлсний үр дүнд Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Их эрдмийн зөвлөлийн хурлаар дэмжигдсэн.	100
			Хулд сумын Олдохын Хүрэн бор тэмээг омог болгон батлуулах сайдын зөвлөлийн хурлын шийдвэрийг гаргуулсан байх тоо	1			
4.2.3	АЗДҮАХ 4.1.6	Гүн өрмийн худгийг шинээр гаргах болон сэргээн засварлах, энгийн уурхайн	Аймгийн хэмжээнд шинээр гаргах гүн өрмийн худгийн тоо	10	Төсөл- 391.0 ОН-198.3	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл төслийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 27 худаг шинээр гаргах	70

		худгийг сэргээн засварлаж усан хангамжийг нэмэгдүүлэх	Энгийн уурхайн худгийг сэргээн засварлах тоо	15		ажлын гүйцэтгэгчээр “Эхний эхэн”, “Гранд холдинг”, “Топ дриллинг” ХХК-иуд шалгарч гэрээ байгуулж 3-р улирлын байдлаар 18 худгийг ашиглалтад хүлээн авлаа. Мөн 10 сум орон нутгийн хөрөнгө оруулалтаар энгийн уурхайн 46 худгийг сэргээн засварласнаар нийт 400,5 мян/га бэлчээрийг усжуулах хийгдэж байна. Гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан “Топ дриллинг” ХХК гэрээний үүргээ зөрчсөний улмаас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх гүн өрмийн 20 худгийг гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлагдан үнэлгээний явцдаа байна.	
4.2.4	АЗДҮАХ 4.2.2.	Дундговийн айраг, ингэний хоормогийг орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болгон баталгаажуулж зах зээлд нийлүүлэх	Гүүний айраг, ингэний хоормог үйлдвэрлэдэг сумдыг хамруулах	4	20.0 Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр		ҮБ
			Брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлсэн байх	2			
4.3 Мал эмнэлгийн чиглэлээр							
4.3.1	АЗДҮАХ 4.1.12 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.5	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Шүлхийн вакцинд Хамрагдах малын тоогоор / сая толгой /	1,0	250.0 Улсын төсөв	Аймгийн Засаг даргын 2020 оны 4 сарын 30-ны өдрийн А/125 захирамжийн дагуу 4 сарын 25-ны өдрөөс 5 сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд Цагаандэлгэр, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Өндөршил, Өлзийт сумдад Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Дархлаажуулалтад 1727 өрхийн 19533 үхэр, 637851 толгой хонь, 561458 толгой ямаа нийт 1218862 толгой мал хамруулан 93%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	100
4.3.2		Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад голомттой нутгийн мэдрэмтгий малыг хамруулах	Вакцинжуулалтад хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/	1,0	50.0 Улсын төсөв Орон нутгийн төсөв	Дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 607 өрхийн 183756 хонь, 92422 ямаа, 15593 хурга, 1321 ишиг бүгд 293092 толгой мал хамрагдсан. Шөвөг яраас урьдчилан сэргийлэх	100

					310.6 Малчид 200.0	дархлаажуулалтанд 242745 төл хамрагдсан. Сохор догол өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 13840 толгой мал хамрагдсан	
4.3.3		Бруцеллёз өвчинтэй тэмцэх стратегийг хэрэгжүүлж тандалт вакцинжуулалт ийлдсийн тандалт хийх	Бруцеллёзын шинжилгээнд хамрагдах хээлтүүлэгчийн тоо /давхардсан тоогоор сая толгой /	18,0	200.0 Улсын төсөв	Аймгийн Засаг даргын 7 сарын 29-ний өдрийн А/192 тоот захирамжийн дагуу 15 сумын хэмжээнд Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дархлаажуулалтанд 1383 өрхийн 3139 тугал, 167763 хурга, 122913 ишиг бүгд 290516 толгой төл хамруулан 53%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Улсын мал эмнэлгийн төв лабораторийн удирдамжаар хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний халдвар илрүүлэх тандалтанд 17138 хуц, ухна, буур, бухнаас сорьц авахаас 11047 сорьцыг цуглуулж 9592 сорьцонд шинжилгээг хийж 110 хуц ухнаас эерэг буюу бруцеллёз өвчин илрээд байна. Уг бруцеллёз өвчин илэрсэн сумдад дахин ажиллахаар бэлтгэл хангаж байна.	40
4.3.4	АЗДҮАХ 4.1.11 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.4	Мал эмнэлгийн тасгийг бэхжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг аттестатчлах	15 сумын мал эмнэлгийн тасгийн ажиллагсдын тоог 18 байгааг нэмэгдүүлэх тоогоор	3	3.0 Улсын төсөв	Сумдын хэмжээнд 10 улсын байцаагч, 8 тархвар зүйч эмч нийт 18 орон тоотойгоор ажиллаж байна 15 сумын мал эмнэлгийн тасгийг бэхжүүлэх ажлын хүрээнд мотоцикль, номын шкаф, ширээ, сандал, компьютер, хэвлэгчээр бүрэн хангаж, тасгийн мэргэжилтнүүдэд ARCGIS системийн сургалт, Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах сургалт, мал эмнэлгийн нэгдсэн системийн сургалтыг ажлын байран дээр нь 34 нэгжийн 55 эмчид зохион байгуулсан. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд мал эмнэлгийн гэрчилгээг гар утаснаас хэвлэх төхөөрөмжийг олгосон. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн шуурхай бэлэн байдлын үзлэгийг 1 сард 35 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хамруулан хийж МЭГ-ийн ахлах байцаагч хугацаатай үүрэг даалгавар өгч	
			Мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хувиар /малын тоо 5,0 /	10			
			Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг аттестатчлалд хамруулах тоо	35			

						ажилласан. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн аттестатчилалын хугацаа болоогүй байна.	
4.4 Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдааны чиглэлээр							
4.4.1	АЗДҮАХ 4.2.7	“Дундговь түншлэл 2020” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бүс, улсын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлэх	“Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн худалдаанд 120 иргэн, ААН оролцсоныг нэмэгдүүлэх хувиар	10	3.5 Орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэр		ХБ
			Борлуулалтын орлогыг 43,2 сая байсныг нэмэгдүүлэх хувиар	10			

ХЯНАСАН:ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА
НЭГТГЭСЭН: СУРГАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ж.ШИНЭ-УЯНГА
Ю.ГАНЦЭЦЭГ